



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/05

Хэрлэн сум

Орон нутаг дахь Хүний эрхийн төлөв  
байдлын тайланд мэдээ, мэдээллээр хангаж,  
нэгтгэх ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоол, “Хүний эрхийг хангах Үндэсний хорооны ажиллах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам” –ын хүрээнд мэдээ, мэдээллээр хангаж, нэгтгэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн  
дарга:

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн  
дарга:

Хууль, эрх зүйн хэлтсийн эрх зүйн сургалт сурталчилгаа,  
хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал  
хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Төрийн Захиргааны Удирдлагын хэлтсийн дарга

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Цэргийн штабын дарга

2. “Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тайлагнах, илтгэх журам” –ыг мэдээ, мэдээллээр хангаж, нэгтгэх ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэдээллийг нэгтгэж, тогтоосон хугацаанд хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга Хууль, эрх зүйн хэлтсийн даргад даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА